



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 5/65

Улаанбаатар хот

Нэг удаагийн буцалтгүй тусламж олгож,  
үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8, 9.6.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2 дахь заалт, 46.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 1.2 дахь заалт, 2 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өөрийн гаргасан хүсэлтийг нь харгалзан өндөр насны тэтгэвэрт гарах болсонтой нь холбогдуулан тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Нэргүйн Бат-Эрдэнийг 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Н.Бат-Эрдэнийн сүүлийн 36 сарын албан тушаалын нэг сарын үндсэн цалингийн дундаж болох 1,466,568.0 (нэг сая дөрвөн зуун жаран зургаан мянга таван зуун жаран найм) төгрөгийг төрийн албанд ажилласан 42 жилийг нь харгалзан 36 сараар үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосугай.

3.Буцалтгүй тусламжид шаардагдах 52,796,456.0 (тавин хоёр сая долоон зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун тавин зургаа) төгрөгийг зохих сангаас олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

4.Н.Бат-Эрдэнийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Болор-Эрдэнэ), холбогдох санхүүгийн тооцоог хийж дуусгахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т тус тус үүрэг болгосугай.



080000430